

**УЛААНБААТАР ХОТЫН СОНГИНОХАЙРХАН
ДҮҮРГИЙН 4 -Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ
ХЭРЭГЖИЖ БУЙ “АЛТАН ТАРИА” ХХК ИЙН ГУРИЛ,
ТЭЖЭЭЛИЙН ҮЙЛДВЭР ТӨСЛИЙН 2025 ОНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

УЛААНБААТАР
2025

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1.1. Төслийн нэр	3
1.2. Төсөл хэрэгжүүлэгч	3
1.3. Төслийн зорилго	3
1.4. Төслийн хүчин чадал	3
1.4.1. Тэжээлийн үйлдвэрийн хүчин чадал	3
1.5. Төслийн технологийн үндсэн дамжлага	3
1.5.1. Гурилын үйлдвэр	3
1.5.2. Тэжээлийн үйлдвэр	4
1.5.3. Түүхий эдийг хадгалах хэсэг	5
1.5.4. Лаборатори	6
1.5.5. А. Түүхий эдийн зориулалттай ашиглах химийн гол бодисууд:	6
1.6. “Алтан тариа” ХХК-ийн нэрийн барааны дэлгүүр	8
“Алтан тариа” ХХК нь гурил, тэжээлийн үйлдвэрийн хашаанд нэрийн барааны дэлгүүртэй бөгөөд өөрийн үйлдвэрлэсэн нэрийн барааны дэлгүүрийг ажиллуулдаг...	8
1.7. Төслийн байршил	9
1.8. Төслийн талбайн дэд бүтцийн хөгжил	10
2. ТӨСЛИЙН ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ	11
2.1. Төсөл хэрэгжих талбайн газрын гадаргын эвдрэл, өөрчлөлт	12
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	13
3.1. Төслийн болзошгүй нөлөөллийг тодорхойлох	13
3.2. Төсөл хэрэгжих үеийн болзошгүй нөлөөлөл:	14
4. 2025 ОНД АШИГЛАХ ХИМИЙН БОДИС	16
5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛГО	17
5.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	17
5.1.1. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	17
5.1.2. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	18
5.1.3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	18
5.1.4. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	18
5.2. Төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	18
6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	20
7. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	22
8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	23
9. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ...	24
10. ОСОЛ, ЭРСДЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
11. УДИРДЛАГА-ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	26
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	28
13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	30
14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	31
15. ДҮГНЭЛТ	32

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Химийн бодсын жагсаалт	6
Хүснэгт 2. Түүхий эдийн шаардлагатай тоо хэмжээ	7
Хүснэгт 3. Болзошгүй сөрөг нөлөөлөл ба эх үүсвэр.....	14
Хүснэгт 4. 2025 онд ашиглах химийн бодис	16

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Гурилын үйлдвэрийн технологийн дамжлага	3
Зураг 2. Гурилын үйлдвэрийн процесс	4
Зураг 3. Том савлах машин	4
Зураг 4. Тэжээлийн үйлдвэрийн технологийн дамжлага	4
Зураг 5. Тэжээлийн үйлдвэрийн процесс.....	5
Зураг 6. Савлах машин	5
Зураг 7. Тариа хадгалах силосоос Тэжээлийн үйлдвэрт холбогдсон шугам.....	6
Зураг 8. Тэжээлийн үйлдвэрийн лаборатори.....	8
Зураг 9. Нэрийн барааны дэлгүүр.....	8
Зураг 10. Төслийн талбайн байршил.....	9
Зураг 11. “Алтан тариа” ХХК-ийн барилга байгууламжийн байршил	9
Зураг 12. Төслийн талбайн орчин.....	10
Зураг 13. Төслийн физик газарзүйн мужлалт.....	12
Зураг 14. Үйлдвэрийн хашаан доторх газрын гадаргын төлөв байдал	12
Зураг 15. Орчны хяналт шинжилгээ явуулах цэгийн байршил	19

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн нэр

“Гурил, тэжээлийн үйлдвэр” төсөл

1.2. Төсөл хэрэгжүүлэгч

“Алтан тариа” ХХК	
Улсын бүртгэлийн дугаар	9011067051
Регистрийн дугаар	2075083
Холбоо барих утас	99099689, 631480

1.3. Төслийн зорилго

Монгол улсын хүн амыг гурилын хэрэгцээгээр хангах мөн хүн амын дийлэнх хэсэг болох мал аж ахуй эрхлэгчдийн амьжиргааг дээшлүүлэх, эрчимжсэн мал аж ахуйг өргөжүүлэн хөгжүүлэхэд мал, амьтдын бүрэн найрлагат тэжээлийг олон төрлөөр үйлдвэрлэн гаргах, хаягдалгүй үйлдвэрлэлийн технологи нэвтрүүлэн үйл ажиллагаа явуулж, үйлдвэрийн тогтвортой хөгжлийг хангахад энэ төслийн зорилго, ач холбогдол оршино.

1.4. Төслийн хүчин чадал

Технологийн дэвшилд өргөтгөл хийж 2009 онд 15 тн/ц хүчин чадалтай тариа цэвэрлэх хэсэг ашиглалтад орсон.

2002 онд хоногт 300 тн/ц хүчин чадалтай тээрэмдэх, хэсэг, савлах хэсгүүд ашиглалтад орсон. Тус гурилын үйлдвэр нь хоногт 250 тн улаанбуудайг тээрэмдэж, 175тн гурил үйлдвэрлэдэг.


1.4.1. Тэжээлийн үйлдвэрийн хүчин чадал

Дэлхийд алдартай Швейцарийн “Buhler” компанийн тоног төхөөрөмж нь цагт 15тн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд 12 цагаар ажиллаж хоногт 180 тн тэжээл үйлдвэрлэдэг.

1.5. Төслийн технологийн үндсэн дамжлага

1.5.1. Гурилын үйлдвэр

Тус гурилын үйлдвэр нь дараах үндсэн технологийн дамжлагын дагуу үйл ажиллагааг явуулна.



Зураг 1. Гурилын үйлдвэрийн технологийн дамжлага



Зураг 2. Гурилын үйлдвэрийн процесс




Зураг 3. Том савлах машин

Үйлдвэрлэсэн гурилыг БГ-045, БГ-050, БГ-055, БГ-075, БГ-140, бүхэл үрийн гурил, хүүхдийн будааг 1 кг-р савлана. Үйлдвэрлэсэн гурилыг /БГ045, БГ050, БГ055, БГ075, БГ140, хүүхдийн будааг 10, 25, 50 кг савлана.

1.5.2. Тэжээлийн үйлдвэр

“Алтан тариа” ХХК-ийн тэжээлийн үйлдвэр нь үйл ажиллагаагаа дараах үндсэн шат дамжлагын дагуу үйл ажиллагааг явуулж байна.



Зураг 4. Тэжээлийн үйлдвэрийн технологийн дамжлага



Зураг 5. Тэжээлийн үйлдвэрийн процесс



Зураг 6. Савлах машин

Бэлэн болсон хорголжилсон бүтээгдэхүүнийг савлалтын бункерт хийж автомат төхөөрөмжөөр 4 төрлөөр бүтээгдэхүүнийг ялган 25-40 кг –аар савлана.

1.5.3. Түүхий эдийг хадгалах хэсэг

Тэжээлийн үйлдвэрт 10 гаруй нэр төрлийн үндсэн түүхий эдүүд ордог. Тариа хадгалах цехээс хаягдал буудай, элеваторын хаягдал, тээрмийн цехээс тээрмийн хаягдлыг тусгай силост хийж хадгалан түүхий эд болгон тэжээлд зохих хувиар ашигладаг. Задгай нийлүүлэгддэг түүхий эдийг силост хийж хадгалах ба уут савтай түүхий эдийг түүхий эдийн агуулахад хадгална. Эдгээр үндсэн түүхий эдүүд нь үр тарианы төрлийн түүхий эдүүд байна.

Түүхий эдийн агуулах нь 78.5м урт, 28м өргөн, нийт 1500м² талбай бүхий нэг зэрэг 15 гаруй нэр төрлийн түүхий эдийг холилдуулахгүйгээр хурааж нөөцлөх боломжтой зориулалтын агуулах юм.



Зураг 7. Тариа хадгалах силосоос Тэжээлийн үйлдвэрт холбогдсон шугам

Тус тэжээлийн үйлдвэр нь орчин үеийн дэлхий нийтийн стандартын шаардлага хүрэн нийцсэн багсармал тэжээл үйлдвэрлэнэ.

1.5.4. Лаборатори

“Алтан тариа” ХХК-ын “Турил, тэжээлийн үйлдвэр”-ийн бүтээгдэхүүний болон шаардлагатай дээжүүдэд хими, физик, микробиологийн хяналт сорилт шинжилгээ хийх дотоод хяналтын сорилын лабораторитой ба лабораторийн дарга, шинжээч нийт 14 ажилтан ажиллаж байна. Бүтээгдэхүүний хяналт сорил хийх дотоод лаборатори нь тэжээлт орчнууд болон 13 нэр төрлийн химийн бодисыг бага хэмжээнд хэрэглэдэг байна. Химийн бодисын зориулалт, физик, химийн шинж чанар, хоруу чанарын мэдээлэл, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх хор хөнөөлийг бүлэгт 8-т үзүүлэв.

Хүснэгт 1. Химийн бодисын жагсаалт

№	Химийн бодисын нэр монгол	Химийн бодисын нэршил	Химийн томьёо	Хэмжих нэгж	Одоо байгаа хэмжээ	Cass номр	Жилийн хэрэглээ
1	Этанол	Ethanol absolute for analysis	C_2H_5OH	Л	3 л	64-17-5	2000 мл
2	Диэтилэфир	Diethylether	$(CH_2CH_2)_2O$	Кг	6 кг	60-29-7	18000 мл
3	Калийн сульфат	Potassium sulfate	K_2SO_4	Кг	1.5 кг	7778-80-5	2000 гр
4	Зэсийн сульфат	Copper (2) sulfate	$CuSO_4$	Кг	0.5 кг	7758-99-8	500 гр
5	Натрийн гидроксид	Sodium hydrate	$NaOH$	Кг	0.5 кг	1310-73-2	10000 гр
6	Борийн хүчил	Boric acid	H_3BO_4	Кг	570 гр	10043-35-3	50 гр
7	Метилийн улаан	Methylene red	$C_{15}H_{15}N_3O_2$	Шил	18.5гр	493-52-7	10 гр
8	Бром ксилол ногоон	Bromocresol green	$C_{48}H_{50}N_4O_4$ $H_2C_2O_4$	Шил	18.5гр	76-60-8	10гр
9	Фенолфталеин	Phenolphthalein	$C_{20}H_{14}O_4$	Кг	3 гр	77-09-8	10 гр
10	Хүхрийн хүчил	Potassium sulfate	H_2SO_4	Кг	4.6 кг	7664-93-9	3500 мл
11	Бензидиний уусмал	Benzidine	$C_{12}H_{12}N_2$	Кл	-	92-87-5	10 гр
12	Давсны хүчил	Hydrogen chloride	HCL	Кл	-	7647-01-0	100 мл
13	Петролейний эфир	Petroleum ether	C_6H_{12}	Кл	-	8032-32-4	180000 мл

1.5.5. А. Түүхий эдийн зориулалттай ашиглах химийн гол бодисууд:

Нэрс:

- Лизин /амин хүчил/
- Метионин /амин хүчил/
- Трионин /амин хүчил/
- Шээг /мочевин/

Эх үүсвэр:

БНХАУ-аас импортлох
БНХАУ-аас импортлох
БНХАУ-аас импортлох
БНХАУ-аас импортлох

- Шохойн чулуу БНХАУ-аас импортлох
- Кальцийн фосфат /кальцийн давс/ БНХАУ-аас импортлох
- Премикс /бордооны, саалийн г.м/ БНХАУ-аас импортлох

Хүснэгт 2. Түүхий эдийн шаардлагатай тоо хэмжээ

№	Түүхий эд		Сард (тн)	Хагас жилд (тн)
1	Wheat, grain	Улаан буудай	750	4.500
2	Wheat, bran	Тэжээлийн хивэг	1000	6.000
3	Wheat, middlings, <9.5% fiber	Тээрмийн хаягдал эслэг <9.5%	333	2.000
4	Wheat, shorts, <7% fiber	Элеваторын хаягдал эслэг <7%	108	650
5	Soymeal	Шар буурцгийн гурил	-	-
6	Cotton seed meal	Хөвөнгийн үрийн гурил	42	250
7	Corn	Эрдэнэшиш	50	300
8	Feed grade barley	Арвай	583	3.500
9	Canola meal	Рапсын шахдас	183	1.100
10	Canola	Рапс	2	10
11	DDGS /corn/	Эрдэнэ шишийн шахдас	83	500
12	Bone meal	Ясны гурил	8	50
13	Bone oil	Ясны тос	33	200
14	Lysine, L	Лизин	2	10
15	Methonine	Метонин	0	1.5
16	Limestone	Шохойн чулуу	50	300
17	Salt (Na Ci)	Давс (NaCi)	30	180
18	Blood meal	Цусны гурил	5	30
19	Threonine, synthetic	Трионин	1	3.0
20	Zeolite	Цеолит	-	-
21	Molasses (sugarcane)	Бурам	63	380
22	Urea	Шээг	37	220
23	Ammonium phosphate	Фосфат	1	4.0
24	Rape oil	Рапсын тос	25	150
25	Vitamin A	Витамин А	-	-
26	Vitamin E	Витамин Е	-	-
27	Sand	Элс	-	-
28	MgO	Магнийн исэл	3	15
29	Soda	NaHCO ₃	5	30
30	Premix	Премикс	23	140
		Бүгд	3.420	20.524

Технологи: Дээрх химийн бодисууд нь үйлдвэрийн технологичийн боловсруулсан жорын дагуу түүхий эдэд орж холигдон тэжээлд шаардлагатай шим тэжээлийн эх үүсвэр болно. Технологийн дамжлагын хувьд холигч машинд үндсэн түүхий эдүүдтэй орж холигдоно. Тус үйлдвэрлэлийн технологийн онцлогоос шалтгаалж эдгээр химийн бодисууд нь гадагш алдагдалгүй битүү горимоор ямар ч хаягдалгүйгээр жорын дагуу хийгддэг. Дозлолт болон холилтыг хяналтын технологич, лаборант нар хөндлөнгөөс хянаж байдаг.

Тодорхойлолтууд:

Амин хүчлүүд: Уураг нь малын бие махбодын үндсэн хэсгийг бүрдүүлж амьдралын хэвийн үйл ажиллагааг хангадаг бодисуудын нэг ба аминохүчилүүдээс бүрддэг. Амьтны уургийг 20 төрлийн аминохүчил бүрдүүлдэг. Эдгээр 20 аминохүчилийн 10 нь амьтны бие махбод дотор нийлэгжих чадвартай (орлогдох аминохүчил) бол үлдсэн 10 аминохүчилийг зөвхөн хоол тэжээлээр (үл орлогдох аминохүчил) авдаг.

Үл орлогдох аминохүчилд:

✓ Арганин

- ✓ Гистидин
- ✓ Изолеуцин
- ✓ Леуцин ($\text{NH}_3\text{-C}_4\text{H}_8\text{-CH-NH}_2\text{-COOH}$)
- ✓ Метионин ($\text{S-C}_3\text{H}_7\text{-CH-NH}_2\text{-COOH}$)
- ✓ Фенилаланин



Зураг 8. Тэжээлийн үйлдвэрийн лаборатори

1.6. “Алтан тариа” ХХК-ийн нэрийн барааны дэлгүүр


“Алтан тариа” ХХК нь гурил, тэжээлийн үйлдвэрийн хашаанд нэрийн барааны дэлгүүртэй бөгөөд өөрийн үйлдвэрлэсэн нэрийн барааны дэлгүүрийг ажиллуулдаг.




Зураг 9. Нэрийн барааны дэлгүүр

1.7. Төслийн байршил


“Алтан тариа” ХХК-ийн “Турил, тэжээлийн үйлдвэр” төсөл нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлана.



Зураг 10. Төслийн талбайн байршил



Зураг 11. “Алтан тариа” ХХК-ийн барилга байгууламжийн байршил



Зураг 12. Төслийн талбайн орчин

1.8. Төслийн талбайн дэд бүтцийн хөгжил

Цахилгаан хангамж: Тус төслийн цахилгаан хангамжийг төвийн цахилгаан шугам сүлжээнд холбогдсон.

Зам харилцаа: Төслийн талбай нь зам харилцаа сайтар хөгжсөн замтай холбогдсон байна.

Дулаан хангамж: Төслийн барилга байгууламж нь дулаан хангамжаа төвийн дулааны шугамаас хангадаг байна.

Цэвэр усны хангамж: Тус төсөл нь төвийн шугам сүлжээнд холбогдсон.

Харилцаа холбоо: Харилцаа холбооны тухайд бүх төрлийн үүрэн телефон холбоо ашиглах боломжтой.


2. ТӨСЛИЙН ФИЗИК ГАЗАРЗҮЙН НӨХЦӨЛ


Улаанбаатар хот орчмын нутаг дэвсгэр нь Монгол орны физик газарзүйн мужлалтаар Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хэнтийн уулсын баруун өмнөд шувтрах үзүүрт Богдхан уулын ард, Туул голын өргөн хөндий ба түүний цутгал голуудаар хэрчигдсэн хэсэгт оршино. Туулын дэнж хотын зүүн хэсэгт нарийн 2.5-3.0 км орчим өргөн, баруун тийш болох тутам өргөсөн хотын баруун талд 5.0-5.5 км орчим өргөн болох ба ерөнхийдөө зүүнээсээ баруун тийшлэх тусмаа намсана. Хотын эргэн тойронд Богдхан уул, Сонгинохайрхан, Баянзүрх, Чингэлтэй уулс хүрээлнэ.

Улаанбаатар хотын нутаг нь гадаргын тогтцын хувьд Хэнтийн нурууны баруун урд шувтарга үзүүрийн буюу Туул голын сав дагуух хавтгайдуу бөмбөгөр оройтой, эгцэвтэр хажуу бүхий дундаж өндөр, нам уулс, тэдгээрээс зүг бүр тийш эх аван урсах голуудын хөндий, дөрөвдөгчийн сэвсгэр хурдсаар дүүргэгдсэн томоохон хотос зэрэг хотгор гүдгэрийн олон хослолоос тогтоно. Нам, дунд өндөрлөгтэй уулын хажуу, бэл, хормой ба Улиастай голын хөндийн хэсэгт байрлана.

Төслийн талбай нь засаг захиргааны хувьд Улаанбаатар хотын Баянгол дүүргийн нутагт орших бөгөөд тус талбай нь Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хэнтийн мужийн Хэнтийн захын уулсын тойрогт хамаарах бөгөөд далайн түвшингээс дээш 1280-1395 м түвшинд өргөгдсөн нутаг юм. Судалгааны талбай нь Хэнтий нурууны урд хэсэг, хангай хээрийн бүсийн зааг хэсэгт тал хээрийн бүс тул талархаг, толгодорхог, нам өндөртэй бэсрэг уулс бүхий гадаргатай.

Төслийн талбай нь газрын гадаргын хувьд тэгш, гадаргын налуу нь 0-4.8°, далайн түвшнээс дээш 1284 м-т өндөрт байрлаж байна.





Зураг 13. Төслийн физик газарзүйн мужлалт

2.1. Төсөл хэрэгжих талбайн газрын гадаргын эвдрэл, өөрчлөлт

Төслийн талбай нь нийслэл хотын хүн ам суурьшсан бүсэд байрлалтай учир ойр орчмын газрын гадарга, хөрс нь техноген нөлөөлөлд нэлээд өртсөн байна.

Төслийн эдэлбэр газрын хэмжээ 123.47 га бөгөөд энэ хэмжээний хөрс, газрын гадарга шууд нөлөөлөлд өртөх юм.



Зураг 14. Үйлдвэрийн хашаан доторх газрын гадаргын төлөв байдал

3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Алтан тариа” ХХК-ийн “Гурил, тэжээлийн үйлдвэр” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг өмнөх хэсэгт авч үзсэнийг нэгтгэвэл 21 үзүүлэлтээр нөлөөллийн эрчмийг тодорхойлсноос төслөөс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн 23.8% нь нөлөөлөлгүй, 52.4% нь бага, 23.8% нь дунд, 0% их нөлөөлөлтэй байна. Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийн эрчим байгаль орчны бусад бүрдэл хэсгүүдээс их байна.

3.1. Төслийн болзошгүй нөлөөллийг тодорхойлох

Байгаль экосистемийн өөрчлөлт: Төслийн үйл ажиллагаагаар унд ахуйн усны хэрэглээг төвийн шугамаас хангах тул газрын доорх усны нөөцөд шууд нөлөөлөх бөгөөд харин гадаргын усны нөөцөд үзүүлэх нөлөөлөлгүй байна. Төслийн үйл ажиллагаагаар хүн, машин техникийн хөдөлгөөн ихсэх зэргээс төслийн талбайд байгаль экосистемийн бүрэлдэхүүн хэсэг болох хөрс, ургамалд шууд нөлөөлнө. Энэ нь төслийн талбайн хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг барилга, байгууламжид дарагдах, талбайн хөрс хүнд машин техникийн нөлөөгөөр дагтарших, ургамлан бүрхэвч талхлагдах, тухайн орчны өнгөн хөрс элэгдэл, эвдрэлд орох зэрэг болно.

Байгалийн баялаг, нөөц ашиглалт: Гурил тэжээлийн үйлдвэр төсөл нь түүхий эдээ байгалаас авч ашиглах тул байгалийн баялагт үзүүлэх нөлөө бага зэргээр үзүүлж болзошгүй. Төслийн түүхий эдийг үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий байгууллагаас ханган нийлүүлэх нь зүйтэй.

Төсөл хэрэгжих талбайн орчим ой мод, ус намгархаг газар байхгүй. Суурьшлын бүсэд хэрэгжих байгаа учир дуу чимээ зэргээр хөрсний амьтдад нөлөөлөл үзүүлэх, ургамлан нөмрөгийг доройтолд оруулах боловч ургамал, амьтны нөөцийг шууд ашиглахгүй тул биологийн олон янз байдалд нөлөөлөх нь бага байна.

Байгаль орчны чанарын өөрчлөлт: Хатуу, шингэн хаягдлыг холбогдох журам, стандартад заасны дагуу зайлуулаагүй нөхцөлд хөрс, газрын доорх усыг бохирдуулах эрсдэлтэй. Төслийн тээврийн хэрэгслийн хөдөлгүүр дэх шаталтаас агаар орчинд хийн хаягдал үүснэ. Төслийн талбай нь үйлдвэр үйлчилгээ хөгжсөн суурьшлын бүсэд хэрэгжих учир дуу чимээ харьцангуй өндөр. Ахуйн шингэн хаягдал, шатах тослох материалын нөлөөгөөр хөрсний чанарт өөрчлөлт орж болзошгүй.

Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, тусгай хамгаалалттай газар нутаг, археологи, палеонтологийн олдвор: Ажилчдад байгаль хамгаалах талаар сургалт сурталчилгаа хийгдээгүй, хангалтгүй нөхцөлд төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэр орчмын хөрс, ургамлын нөмрөг талхлагдах, доройтох нөлөөлөл үзүүлж болзошгүй. Төсөл нь улсын тусгай хамгаалалттай газар нутагт хэрэгжихгүй. Гурил, тэжээлийн үйлдвэрийн үйл ажиллагаа явуулж буй талбайд түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн ховор олдворын зүйл байхгүй учир төслийн үйл ажиллагаанаас нөлөөлөлгүй болно.

Эдийн засаг, нийгмийн асуудал: Гурил, тэжээлийн үйлдвэрийн төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор ажлын байр нэмэгдэнэ. Орон нутгийн төсөвт тодорхой хэмжээний татвар төлнө. Тодорхой тооны иргэдийг ажлын байраар хангах, тэдний амьжиргаанд тус нэмэр болох, ядуурлыг бууруулахад дэмжлэг болохоос гадна дэд Хөдөө аж ахуйн салбарт нөлөөлөх зэрэг эерэг нөлөөллүүд гарна.

Бусад нөлөөлөл: Төсөл нь үйл ажиллагаандаа хор аюулын зэрэг өндөртэй химийн бодис ашиглахгүй. Хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавж үржих зэргээс урьдчилан сэргийлж, халдваргүйжүүлэх, нян устгах ариутгалыг тогтмол хугацаанд хийж байх нь зүйтэй. Төсөл хэрэгжих явцад ажилчдын хариуцлагагүй байдал, болгоомжгүй

үйлдлээс үүдэн гал түймэр гарч болзошгүй. Тухайн үед яаралтай арга хэмжээ аваагүй нөхцөлд байгаль орчинд их хэмжээний хохирол учруулахаас гадна нийгэм, эдийн засгийн хувьд ч хүчтэй сөрөг нөлөө үзүүлнэ.

Нөлөөллийн хэлбэр: Шууд нөлөөлөл – Гурил, тэжээлийн үйлдвэр төслийн үйл ажиллагаанаас үүдэн гарч болзошгүй шууд нөлөөлөл 16 /72.7%/ байна. Шууд нөлөөллөөс 12 /75%/ нөлөөлөл сөрөг, 4 /25%/ нөлөөлөл эергээр нөлөөлнө. Төслийн үйл ажиллагааны явцад газрын доорх ус, ургамлан нөмрөг, хөрс, агаарт шууд сөргөөр нөлөөлөх талтай бол орон нутгийн эдийн засгийн байдал, ажлын байр нэмэгдэх зэрэгт шууд эергээр нөлөөлөхөөр байна.

Шууд бус нөлөөлөл - Үүнд 4 /22.8%/ төрлийн нөлөөлөл багтаж байна. Шууд бус нөлөөллөөс 4 /80%/ сөрөг, 1 /20%/ нөлөөлөл эергээр нөлөөлнө. Үүнд, газрын доорх ус, геологийн тогтоц өөрчлөгдөх, ой, ус намгархаг газар, тусгай хамгаалалттай газар нутаг, түүх соёлын дурсгалт зүйлд шууд бус сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй бол төсөл хэрэгжсэнээр ядуурлыг бууруулахад шууд бус эерэг нөлөө гарна.

Нөлөөллийн үргэлжлэх хугацаа: Болзошгүй нөлөөллийг үргэлжлэх хугацаагаар нь авч үзвэл богино хугацааны нөлөөлөл 7 /31.8%/, урт хугацааны нөлөөлөл 15 /68.2%/ байна. Нөлөөллийн ихэнх нь урт хугацааны нөлөөлөл байгаа нь төслийн хэрэгжүүлэх хугацаанд сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөгөөний дагуу байнга тасралтгүй хийж байх шаардлагатайг харуулж байна.

Нөлөөллийн чиглэл: Энэ хүрээнд нийт болзошгүй нөлөөллийг “буцалттай нөлөөлөл” болон “буцалтгүй нөлөөлөл” гэж 2 хэсэгт хувааж үзэв. Төслийн үйл ажиллагаанаас 15 /81.8%/ нөлөөлөл буцалттай буюу үр дагавар нь ирээдүйд арилах боломжтой нөлөөлөл байна. Нөгөө талаар энэ нь төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлж буй нөлөөллүүд байгалийн нөхөн сэргэх боломжид сөрөг нөлөөлөл үзүүлэх нь бага байгааг харуулж байна. Харин нийт нөлөөллийн 4 /18.2%/ нь буцалтгүй нөлөөлөл байгаа бөгөөд тухайн өөрчлөгдсөн зүйлс эргэн хивэндээ орохгүй чиглэлтэй байна. Байгаль орчинд сөргөөр, буцалтгүй байдлаар нөлөөлөх тохиолдолд түүнд сөрөг нөлөөлөл багатай үйл ажиллагааг төлөвлөн явуулах, үр ашигтай, хэмнэлттэй ашиглах нь зүйтэй.

Нөлөөллийн эрчим: Төслийн сөрөг нөлөөллийн эрчмийг тодорхойлсон хэсгээс үзэхэд нийт 35 нөлөөллөөс 36.4% буюу 8 нөлөөлөл дунд зэрэг, 63.6% буюу 14 нөлөөлөл бага зэрэг эрчимтэйгээр нөлөөлж байна. Төслөөс үзүүлэх хүчтэй сөрөг нөлөөлөл байхгүй байгаа ч дунд эрчимтэй, сөрөг нөлөөллүүдийг онцгойлон анхаарч, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах ажлыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллавал сөрөг нөлөөллийн эрчмийг бууруулах, нөлөөлөл багатайгаар үйл ажиллагаа явуулах боломжтой юм. Төслөөс улс, орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх, ажлын байр шинээр бий болох, ядуурлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх, тухайн нутаг дэвсгэрийн нийгэм-эдийн засагт дунд зэрэг, эерэг нөлөөлөл үзүүлнэ.

3.2. Төсөл хэрэгжих үеийн болзошгүй нөлөөлөл:

“Алтан тариа” ХХК-ийн “Гурил, тэжээлийн үйлдвэр” төслийг хэрэгжүүлэхэд хүрээлэн буй орчинд учирч болзошгүй нөлөөллийг тодорхойлсон үр дүнд үндэслэн нөлөөллийн эх үүсвэр, шинж чанарыг тодорхойлж дараах хүснэгтэд үзүүлэв. Өмнө нь хийгдсэн болзошгүй нөлөөллийн судалгааны дүнгээс үзвэл тус гурил, тэжээлийн үйлдвэр төслөөс байгаль орчинд үзүүлэх гол сөрөг нөлөөлөл нь:

Хүснэгт 3. Болзошгүй сөрөг нөлөөлөл ба эх үүсвэр

№	Нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж чанар
Агаар орчин			

1	Тоосжилт (PM _{2.5} , PM ₁₀)	- Ажилчдын хөл хөдөлгөөн - Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн	- Тархах хүрээ хязгаарлагдмал. - Салхины хурд бриксийн хурдаас давах, агаарын температур их үед үүснэ.
2	Хийн хаягдал (Утаа, Угаар, SO, NO, CO)	- Тээврийн хэрэгсэл, машин техник механизмын хөдөлгүүр	- Агаарыг бохирдуулах боловч хадгалагдах болон тархах хүрээ хязгаарлагдмал.
<i>Усан орчин</i>			
3	Усны нөөцийн хомсдол	- Унд ахуйн усны хэрэглээ - Технологийн усны хэрэглээ	- Ажилчдын унд-ахуй ус хэрэглээ - Технологийн усны хэрэглээ
4	Хатуу болон шингэн хаягдал	- Ахуйн хог хаягдал - Шатах тослох материалын хаягдал	- Гадаргын ус бохирдох бусад эх үүсвэрүүд - Газрын доорх усны бохирдолд өртөгдөх байдал - Удаан сарнина. - Гадаргын хэлбэршил
<i>Хөрсөн бүрхэвч</i>			
5	Элэгдэл, эвдрэл	- Үйлдвэрлэлд ашиглагдах түүхий эдийн хадгалалт	- Хөрсний физик, механик шинж чанар өөрчлөлт орох. - Тархалтын хүрээ хязгаарлагдмал. - Тархалтыг хязгаарлах боломжтой. - Ямар нэг хэмжээгээр нөхөн сэргээх боломжтой.
6	Бохирдол	- Ахуйн хог хаягдал - Шингэн хаягдал - Шатах тослох материалын асгаралт	- Тархах хүрээ хязгаарлагдмал. - Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн шинж чанар алдагдана. - Хөрсний бохирдол шингээх хурд
<i>Ургамлан бүрхэвч</i>			
7	Ургамлан нөмрөг талхлагдах	- Ашиглалтын талбай, барилга байгууламжийн орчим	- Хэмжээ хязгаарлагдмал. - Ургамлын төрөл зүйл устах. - Ногоон байгууламж, тарималжуулалт хийснээр нөхөн сэргээх боломжтой.
<i>Нийгэм-эдийн засгийн орчин</i>			
8	Ажилчид	- Хүн амын эрүүл мэнд, ажил эрхлэх чадавх дээшилнэ.	- Хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө харьцангуй бага.
9	Үндсэн хөрөнгө	- Татварын эх үүсвэр	- Улсын төсөвт хувь нэмэр оруулна.
10	Шинэ ажиллагсад	- Ажлын байр бий болно.	- Орон нутгийн иргэд орлогын тогтмол эх үүсвэртэй болно.

Магадлан жагсаах аргаар тооцсон дүн

Магадлан жагсаах аргаар нөлөөлөл тодорхойлсон дүнгээс үзэхэд тус төсөл нь байгаль орчинд нөлөөлөх байдлаараа “бага-дунд” нөлөөлөлтэй байна.

4. 2025 ОНД АШИГЛАХ ХИМИЙН БОДИС

“Алтан тариа” ХХК-ын “Турил, тэжээлийн үйлдвэр”-ийн Бүтээгдэхүүний хяналт сорил хийх дотоод лабораторид 2025 онд 13 төрлийн 0.41408 тонн химийн бодис ашиглахаар байна.

Хүснэгт 4. 2025 онд ашиглах химийн бодис

№	Монгол нэр	Олон улсын нэр	Томьёо	CAS дугаар	1 жилийн хэрэглээ
1	Хүхрийн хүчил	Sulfuric Acid	H ₂ SO ₄	7664-93-9	1700 мл
2	Диэтилийн эфир	Diethyl ether	(CH ₂ CH ₂) ₂ O	60-29-7	3600 мл
3	Натрын гидроксод	Sodium hydroxide	NaOH	1310-73-2	400 кг
4	Метил улаан	Methyl red	C ₁₅ H ₁₅ N ₃ O ₂	493-52-7	10 гр
5	Бром ксилол ногоон	Bromocresol green	C ₄₈ H ₅₀ N ₄ O ₄ H ₂ C ₂ O ₄ H ₃ BO ₄	76-60-8	10 гр
6	Борийн хүчил	Boric acid	H ₃ BO ₄	10043-35-3	50 гр
7	Давсны хүчил	Hydrogen chloride	HCl	7647-01-0	100 мл
8	Калийн сульфад	Potassium sulfate	K ₂ SO ₄	7778-80-5	2000 гр
9	Зэсийнс сульфад	Copper (2) sulfate	CuSO ₄	7758-99-8	500 гр
10	Этанол	Ethanol	C ₂ H ₅ OH	64-17-5	2000 мл
11	Петролейный эфир	Petroleum ether	C ₆ H ₁₂	8032-32-4	3600 мл
12	Фенолфталеин	Phenolphthalein	C ₂₀ H ₁₄ O ₄	77-09-8	10 гр
13	Бензидиний уусмал	Benzidine	C ₁₂ H ₁₂ N ₂	92-87-5	500 гр

5. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГӨЛ ЗОРИЛГО

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго: “Алтан тариа” ХХК-ийн “Турил, тэжээлийн үйлдвэр” төслийн үйл ажиллагааг явуулахдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх, байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд үр дүнтэй байгаа эсэхийг тогтооход оршино. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласнаар доорх зорилтуудыг хангана. Үүнд:

- Байгаль орчны хууль тогтоомжийн холбогдох зүйл заалт, журам заавар, стандартын шаардлагад нийцүүлэн төслийн үйл ажиллагааг явуулна.
- Байгаль орчны менежментийн асуудлаар БОННУ-ний тайланд боловсруулан тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг хэрэгжүүлнэ.
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлийг урьдчилсан тооцсоноор байгальд шууд болон шууд бус хэлбэрээр үзүүлэх нөлөөллийг бууруулах, байгаль орчны төлөв байдлыг хадгалж, хамгаална.
- Сум, орон нутгийн удирдлага, хяналтын байгууллага, ард иргэдтэй байгаль хамгаалах асуудлаар зөвлөлдөж, тэдний саналыг авч хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.

5.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Алтан тариа” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах баримт бичиг юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам -наас гаргасан ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан шаардлагуудтай уялдуулан боловсруулсан ба тэдгээрийн хэрэгжилтийг 5 жилийн хугацаанд буюу 2024-2028 оны хугацаанд төлөвлөв. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг холбогдох журам, ерөнхий үнэлгээгээр тавигдсан шаардлагын дагуу урьдчилсан байдлаар тодорхойлж тусгав. Эдгээр зардлууд нь байгаль орчныг хамгаалах ажлын шууд зардлууд бөгөөд түүнтэй холбогдон гарах бусад зураг төслийн буюу туслах чанарын ажлуудын зардал ороогүй. БОХТ-ний биелэлтийн үр дүнгийн жил бүрийн тайланг тухайн оны 11 сарын 1-ний дотор Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам-нд ирүүлж, мөн орон нутгийн засаг захиргааны байгууллага, хорооны иргэдэд танилцуулж, хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах шаардлагатай.

5.1.1. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө нь газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөлд өртөн нөхөн сэргэхгүй газарт биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний

төлөвлөгөөг гаргадаг ба уг төслийн хувьд дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг боловсруулах шаардлагагүй болно.

5.1.2. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Тус төслийн талбай нь Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 4-р хорооны нутагт хэрэгжиж байна. Төслийн талбай нь тусгай хамгаалалттай газар нутаг болон бусад газар ашиглагч нарын зөвшөөрөл бүхий газартай давхцалгүй тул нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөгдөөгүй болно.

5.1.3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбайд түүх, соёлын өв илрээгүй. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сумын засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах шаардлагатай.

5.1.4. Эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Энэхүү төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлыг Удирдлага-зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд тусгалаа.

5.2. Төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

“Алтан тариа” ХХК-ийн “Турил, тэжээлийн үйлдвэр төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчмийг харгалзан үзэж, түүний нөлөөллийн бүсийн талбайг хамруулан байгаль орчны хяналт шинжилгээний мониторингийн системийг байгуулах нь зүйтэй.

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” /ОХШХ/ гэнэ. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой.

Агаар орчин

ОХШХ-т тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж, дүгнэлт гаргуулж байх, шаардлагатай тохиолдолд холбогдох арга хэмжээг авна. Хийн бохирдлын менежмент нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амрагч, ажилчид, нутгийн оршин суугчдын ажиллах, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байх ёстой буюу төлөвлөлтийн холбогдох үндсэн шалгуурууд агаарт хаяж буй бохирдуулагчдад тавигдах ёстой.


Усны чанар

Усны чанарын шинжилгээг төсөл хэрэгжих хугацаанд хийлгэх хяналт шинжилгээг графикт хугацаанд нь шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулан, бохирдол илэрсэн тохиолдолд мэргэжлийн байгууллагатай хамтран түүнийг арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Хөрсөн бүрхэвч

Хөрсний бохирдлын түвшинг дотоодын магадлан итгэмжлэгдсэн лабораториор гүйцэтгүүлэх, хяналт шинжилгээний хөтөлбөрт тогтоосон сорьц авах цэгүүд дээр

үргэлжлүүлэх, сорьцын шинжилгээний төрөл хэлбэрийг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу графикт хугацаанд нь хийлгэж дүгнэлт гаргуулж байх.



Зураг 15. Орчны хяналт шинжилгээ явуулах цэгийн байршил

6. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, өртөгч	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ (5 жилээр)	Нэгж зардал (.төг)	Нийт зардал (.төг)	Хэрэгжүүлэгч	Хамтран хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ									
Тээврийн хэрэгслээс ялгарах хийн хаягдал Тоосжилт	Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгслүүдийг үзлэг оношилгоонд хамруулах	Үйлчилгээний 12 автомашин	удаа	-	400.000	“Алтан тариа” ХХК	Мэргэжлийн байгууллага, компани	-	“Агаарын тухай хууль” “Агаар бохирдлын төлбөрийн тухай хууль” MNS 4585:2016
Хөрсний элэгдэл, эвдрэл	Төслийн талбайд ногоон байгууламж байгуулах, тарималжуулалтын ажлыг хийж гүйцэтгэх. Эдгээр нөлөөллүүдийг зэрэг бууруулах боломжтой.	Төслийн талбайд	-	-	-	“Алтан тариа” ХХК	Мэргэжлийн байгууллага, ажилчид	Ногоон байгууламж, тарималжуулсан талбай Суулгац тариалсан талбай	MNS 5916:2008 MNS 5918:2008 MNS 6260:2011 MNS 5973:2009
Дуу чимээ									
Хийн хаягдал, Тоосжилт	Орчны агаараас сорьц дээж авч, мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэж, түвшинг тодорхойлуулан, заавар зөвлөмж авч ажиллах	Агаарын чанар	Жилд 4-өөс доошгүй удаа	ОХШХ-т тусгагдсан.		“Алтан тариа” ХХК	Мэргэжлийн байгууллага, судлаач	Шинжилгээний дүн	MNS 4585:2016
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ									
Усны нөөц, хэрэглээ	Усыг хэмнэх төхөөрөмжийг үйлчилгээндээ ашиглах /ус хэмнэгч хошуу/	Ариун цэврийн өрөө, бусад хэсэг		-	-	“Алтан тариа” ХХК	Нийлүүлэгч байгууллага		
	Хурын ус хуримтлуулах төхөөрөмж			-	1.800.000	“Алтан тариа” ХХК	Нийлүүлэгч байгууллага		-
Ус ашиглалт	Усны төлбөр төлөх	Гадаргын болон гүний усны нөөц, чанар	Усны нөөц хэмнэх	Гэрээний дагуу тоолуурын заалтаар төлбөр төлөх	-	“Алтан тариа” ХХК			Усны тухай хууль
Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, газрын гадаргад үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ									
Ургамлан нөмрөг талхлагдах.	Төсөл хэрэгжих талбай, хашаанаас гадна хог хаягдал хаяхгүй, газрын	Ойр орчмын хөрсөн бүрхэвч.	Тогтмол	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан.		“Алтан тариа” ХХК			“Хог хаягдлын тухай хууль”

хөрсөн бүрхэвч бохирдох	гадарга, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэрэгжүүлж байх	ургамлан нөмрөг					
Ургамлан нөмрөг талхлагдах, хөрсөн бүрхэвч бохирдох	Хөрсөнд шатах тослох материал алдагдахаас сэргийлж гэмтэл, эвдрэлтэй машин техникийг ажлын талбайд гаргахгүй байх	Хөрс хамгаалал	Удирдлага зохион байгуулалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой		“Алтан тариа” ХХК		
	Эзэмшил газрын хог хаягдлыг цэвэрлэх, эвдэрсэн хөрсийг засаж тэгшлэх,	Хөрс, ургамлан нөмрөг	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан.		“Алтан тариа” ХХК		
Хөрс элэгдэх, ургамлан нөмрөг талхлагдах	Хатуу хаягдлыг ахуйн гарал үүслээр нь ялган ангилж, хураан хуримтлуулах зориулалтын цэгт хогийн сав байршуулах	Хог хаягдлын менежмент	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан.		“Алтан тариа” ХХК		
	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхдээ сумын ТҮК-тэй гэрээ байгуулах		Үйл ажиллагааны зардалд тусгагдсан.		“Алтан тариа” ХХК		
Нийт: 2.200.000							

7. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт
Элэгдэл эвдрэлд орсон газрыг нөхөн сэргээн, ногоон байгууламж бий болгох	Орчны тохижилтыг сайжруулан төслийн талбайд ногоон байгууламж хийх	Улиас	Ширхэг	50	5000	250.000	Төсөл хэрэгжих хугацаанд	- Байгаль орчин, эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт - MNS5914:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хамгаалалт.MNS5916:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага.
		Хайлаас	Ширхэг	50	4500	225,500		
		Нийт				475.000		
Шаардагдах техник, хэрэгсэл		Хүрз	ш	-	-			
		Ухуур	ш		-	-		
		Усалгааны сав	ш	-	-	-		
		Усны шланк	м	-	-	-		
		Модны хайч	ш	-	-	42.000		
		Бордоо	25 кг	50 уут	25000	500.000		
	Хар шороо	1 машин		-	272.000			
Ногоон байгууламж байгуулах зардал		Арготехникийн ажиллагаа				400,000		
		Суулгацыг тээвэрлэх зардал				100,000		
		Ажилчдын хөлс				-		
Арчилгаа, тордлогоо	Ногоон байгууламжийн усалгаа тайралт, хэлбэржүүлэлт хийх	Төслийн талбайд				120.000	Төсөл хэрэгжих хугацаанд	
Нийт дүн 1.909.000								

8. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө							
Ахуйн болон химийн аюултай хатуу хог хаягдал	Ахуйн хог хаягдал түр хадгалах сав байгуулах, хог түр хадгалах цэгт цугларсан хогийг тогтмол хугацаанд зөвшөөрсөн цэгт тээвэрлүүлж байх	Үйлдвэрийн хашаанд	1 ш/удаа	-	400.000	“Алтан тариа” ХХК	“Хог хаягдлын тухай хууль” “Хог хаягдлын тухай хууль” MNS 5344:2003
	Хатуу хог хаягдлыг ангилан ялгах менежментийг сайжруулах, ажилчдад сургалт зохион байгуулах	Төслийн хүрээнд	Улиралд 1 удаа	Зардал тусгах шаардлагагүй.		“Алтан тариа” ХХК	
	“Хог хаягдлын гэрээ” байгуулан, гэрээний дагуу хог хаягдлыг төвлөрсөн цэгт зөөж зайлуулах, тээвэрлүүлэх	Төслийн хэмжээнд	Тогтмол	Гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр. Үйл ажиллагааны зардалд тусгагдсан.		“Алтан тариа” ХХК	
	Химийн бодисын сав баглаа боодлыг аюулгүй зайлуулах, устгах мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулах	Төслийн хүрээнд	Төсөл хэрэгжих бүх үе шатанд	Гэрээнд заасан үнийн дүнгийн дагуу төлөх. Үйл ажиллагааны зардалд тусгах		“Алтан тариа” ХХК	
	Химийн бодисын сав баглаа боодлыг хүлээн авсан, хүлээлгэн өгсөн мэдээллийн сан, бүртгэл үүсгэх	Төслийн хүрээнд	Төсөл хэрэгжих бүх үе шатанд	-		“Алтан тариа” ХХК	
	Гадаад талбайд хог хаягдлыг ангилан ялгаж хаях боломжтой хогийн савыг байрлуулах, хаягжуулах	Үйлдвэрийн хашаанд	10 ш	250.000		“Алтан тариа” ХХК	
Хог хаягдал хуримтлагдах	Төслийн талбай орчныг бохирдуулахаас сэргийлж, хорооны холбогдох байгууллагатай хамтран ойр орчимд тогтмол цэвэрлэгээ хийж байх	Ойр орчмын 50 метр газарт	Жилд 1 удаа	Үйл ажиллагааны зардалд тусгах		“Алтан тариа” ХХК	
Удаан задардаг хатуу хог хаягдал үүсэх	Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх	Төслийн хүрээнд	Тухай бүр т нь	-	Зардал тусгах шаардлагагүй.	“Алтан тариа” ХХК	
Ялаа шавж үржих, өвчин гарах	Хог хаягдлын цэгт ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх, орчныг бохирдуулахаас сэргийлэх	Хатуу хог хаягдлын цэгт	Улирал бүр 1 удаа	Холбогдох байгууллагатай хийсэн гэрээнд заасан төлбөрийн хэмжээгээр		“Алтан тариа” ХХК	
Нийт зардал			650.000 төгрөг				

9. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Гүйцэтгэгч	Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
Химийн бодисын ашиглалт, хадгалалтын үе шат					
ХБ-ын хадгалалт, ашиглалтын явцад асгарах, ХХД алдагдсанаар ажиллагсдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Химийн бодисын хадгалах шүүгээний бүрэн бүтэн байлгах, засвар үйлчилгээний зардал	400.000	Ажил эхлэхийн өмнө	“Алтан тариа” ХХК	“Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” “Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам” MNS 5029:2011 MNS 6458:2014 MNS /ISO/ 13688:2000
	Химийн бодисын агуулахын засаж сайжруулах зөвлөмж	1.000.000			
	ХБ-той ажиллах ажиллагсдыг хөдөлмөр хэрэгслээр бүрэн хангах	-	Тогтмол		
	Ажилчдад химийн бодистой харьцаж ажиллах зааварчилгаа, сургалт явуулах	100.000	Ажил эхлэхийн өмнө		
	Вермикулят, шингээгч материалыг бэлэн байлгаж, яаралтай арга хэмжээ авах төлөвлөгөөтэй байх, орон нутгийн онцгой байдлын газарт мэдэгдэх	Үйл ажиллагааны зардалд тусгагдсан	Тухайн нөхцөл бүрдсэн үед		
Ослын эрсдлээс урьдчилан сэргийлэх					
Химийн бодисын агуулахын битүүмжлэл алдагдаж, агаар, ус, хөрсөөр тархах, ХБ-ын ашиглалтын үед асгарч алдагдах	ХБ-г өртсөн үед яаралтай тусламж үзүүлэх хэрэгсэл, эмийн сан бий болгож, тодорхой газар байрлуулах	40.000	Химийн бодисын ашиглалтын бүх хугацаанд	“Алтан тариа” ХХК	“Гамшгаас хамгаалах тухай хууль” “Галын аюулаас урьдчилан сэргийлэх заавар”
ХБ-ын агуулах болон лабораторид гал гарах	Лабораторийн өрөөнүүдэд галын аюулыг эсрэг хэрэгслээр хангах /галын хор, элс, хүрз, хувин г.м/	40.000			
Нийт зардал			1.580.000 төгрөг		

10. ОСОЛ, ЭРСДЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюуд сөрөг нөлөөллүүд	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, төг	Нийт зардал (.төг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Биелэл-тийн шалгуур Баримтлах хууль журам, стандарт, аргачлал
1	2	3	4	5	6	7	8	9	
Гэнэтийн болзошгүй осол эрсдэл									
1	Газар хөдлөлт	Зохих зураг төслийн стандартыг ашиглан гүйцэтгэгч байгууллагад шаардлага тавих, байгууламжийг улсын комисст хүлээлгэн өгөх	Төслийн талбай	ш удаа	1	-	20,000	1 удаа	Монголын засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”
2	Аянга цахилгаан	Аянга зайлуулагчийг ЦС-ын байгууламжийн ойролцоох өндөрлөг газруудад суурилуулах. ЦС-ын цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байх	Төслийн талбай	Ш удаа	1	-	60,000	1 удаа	Цахилгаан техникийн байгууламжийн угсралтын ажлын аюулгүй ажиллагааны дүрэм
3	Аадар бороо	Барилга байгууламжуудын зураг төсөл, чанарт цаг агаарын нөхцөлүүдийг тусгах, үерээс хамгаалсан далан байгууламжтай болгох	Төслийн талбай	Иж бүрэн	-	-	100,000	1 удаа иж бүрэн	
4	Шороон шуурга	Онцгой байдлын журам боловсруулан мөрдөж ажиллах	Төслийн талбай	-	тогтмол	-	-	Тогтмол	
5	Халдварт өвчин	Өндөр эрсдэлтэй амьтадтай (шувууд) харьцахгүй байх хангалттай хэмжээний хамгаалалтын хэрэгсэлтэй байх (амны хаалт гэх мэт)	Төслийн талбай	Боодол	10	-	40,000	тогтмол	
6	Химийн аюултай бодис асгарах	Ашиглалт, тээвэрлэлт, хадгалалт зэрэгт анхаарал хандуулж холбогдох журам боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай	Төсөл хэрэгжих бүс нутаг	-	Тогтмол	-	-	тогтмол	
Нийт: 220.000 төгрөг									

11. УДИРДЛАГА-ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, төгрөг	2025	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх		+	“Алтан тариа” ХХК	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн зөвлөмж, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дагаж мөрдөх
2	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 2 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	100.000	+	Захирал Мэргэжлийн зөвлөх үйлчилгээний компани	Ажилчдад байгаль орчныг хамгаалах мэдлэг олгох, байгаль болон үйл ажиллагаанаас үүсэн гарах гэнэтийн осол эрсдэлээс сэргийлэх зэрэг мэдлэг олгох зорилгоор сургалт зохион байгуулах. 20234 онд 1 удаа, мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах боломжтой.
3	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Үйл ажиллагааны зардалд тусгах	+	“Алтан тариа” ХХК	Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр
4	Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол оруулах. Ажилчдыг ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, Хордлого тайлах хүнс, эмээр хангаж байх	Дотоод зардлаар	+	“Алтан тариа” ХХК	Ажиллагсдыг мэргэжлийн эмчийн үзлэгт тогтмол харуулж ажиллах
5	Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах	200.000	+	“Алтан тариа” ХХК	-
6	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Нийслэлийн ЗДТГ-т хүргэн өгч байх	-	+	“Алтан тариа” ХХК	-
7	Газар, ус, цахилгаан ашигласны болон бусад төлбөр	Дотоод зардлаар	+	“Алтан тариа” ХХК	“Газрын төлбөрийн тухай хууль”, “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль”-ийг дагаж мөрдөх
8	Химийн бодисын сав баглаа боодлыг устгах “Химийн хортой болон аюултай бодисын хаягдлыг устгах байгууллагын дотоод журам” боловсруулах, химийн бодис болон аюултай хог хаягдлын бүртгэл, мэдээллийн сан үүсгэх	-	+	“Алтан тариа” ХХК	“Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль

9	Химийн бодисын үлдэгдлийн тайлан, мэдээг Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам -нд жил бүр хүргүүлж тайлагнаж байх	-	+	“Алтан тариа” ХХК	“Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль
11	Химийн бодисын сав баглаа боодлыг аюулгүй зайлуулах, устгах мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулах	Гэрээнд заасан үнийн дүнгийн дагуу төлөх. Үйл ажиллагааны зардалд тусгах	+	“Алтан тариа” ХХК	“Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль
12	Хог хаягдлын гэрээ байгуулах Хог түр хадгалах цэгт цугларсан хогийг тогтмол хугацаанд зөвшөөрсөн цэгт тээвэрлүүлж байх	-	+	“Алтан тариа” ХХК	“Хог хаягдлын тухай хууль” MNS 5344:2003
13	Төслийн талбай орчмын иргэдийн санал хүсэлтийг харгалзан сумын иргэдэд тулгамдаж буй асуудлыг шийдэж өгөхөд дэмжиж туслах, нийгмийн хариуцлагын гэрээ байгуулах	-	+	“Алтан тариа” ХХК	
14	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллах	-	+	“Алтан тариа” ХХК	“Хог хаягдлын тухай хууль” MNS 5344:2003
15	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхдээ дүүргийн ТҮК-тэй хийсэн гэрээний дагуу зайлуулах	-	+	“Алтан тариа” ХХК	“Хог хаягдлын тухай хууль” MNS 5344:2003
16	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж жил бүр батлуулж байх	-	+	“Алтан тариа” ХХК	
17	Байгаль орчны аудит хийлгэх	12.000.000	+	Мэргэжлийн байгууллага	
Нийт: 12.300.000					

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

1. АГААРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									
1.1.	Хорт хийн агууламж: Азотын давхар исэл (NO ₂) Хүхэрлэг хий (SO ₂) Нүүрстөрөгчийн дутуу исэл (CO ₂), CO, HCN, O ₂ .	мкг/м ³	Хатуу хог хаягдлын цэг болон авто машины зогсоолын ойролцоо 1 цэгт	Жилд 4 удаа	160.000	1.280.000	“Алтан тариа” ХХК	Мэргэжлийн байгууллага, судлаач	MNS 4585:2016. MNS 6063:2010 MNS 4585:2016 MNS 5606:2008
1.2.	Агаарын тоос тоосонцор (PM _{2.5} , PM ₁₀)	мкм	Төслийн талбайд орчимд тоосжилт үүсэх эх үүсвэр орчимд 1 цэгт						
2. УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									
2.1.	Усны химийн шинжилгээ Био идэвхит нэгдлүүд Нян судлалын үзүүлэлт: Нянгийн тоо Гэдэсний бүлгийн савханцар Эмгэг төрөгч бактери Cl.perferringens	мг/дм ³	Унд-ахуйн ус	Жилд 2 удаа	90.000	180.000	“Алтан тариа” ХХК	Усны лаборатори, Ус цаг уур орчны шинжилгээний газар	MNS 4943:2015 MNS 4586:2024 MNS 0900:2018
		1 мл-т илрүүлэх 100 мл-т							
3.ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ									
3.1.	Хөрсний физик, агрохимийн үндсэн үзүүлэлтүүд: Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO ₃ , P ₂ O ₅ , K ₂ O)	мг	Ногоон байгууламжийн ойролцоо,	Жилд 4 удаа	80.000	320.000	“Алтан тариа” ХХК	Хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори, Магадлан итгэмжлэгдсэн хөрсний лабораториуд	MNS 5850:2019 MNS 6824:2020 MNS3310:1991 MNS ISO 11466:2007

3.2.	Хөрсний хүнд элементүүд /Pb, Cr, Cd, Ni, Co/		Хатуу хог хаягдлын цэг эсвэл авто зогсоолын ойролцоо	Жилд 4 удаа	90.000	360.000	“Алтан тариа” ХХК		
1. ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТ									
4	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, Дуу чимээний норматив, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага		Үйлдвэрийн байранд /иж бүрэн/	Улирал бүр 1 удаа	100.000	400.000	“Алтан тариа” ХХК	Мэргэжлийн байгууллага, судлаач	MNS 5002:2000
1 жилийн ОХШХ-ийн нийт зардал						2.540.000			

13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ							
БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар	Хэрэгжүүлэгч	“БОНХЯ-ны сайдын 2014 оны 1-р сарын 06-ны өдрийн А-03 тоот журам” Олон нийтийн оролцоо, хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд
Дүүргийн байгаль орчны газар	Шинжээчдийн дүгнэлтээр баталгаажна.	Тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайлан	Жил бүрийн 11-р сарын 1-ний дотор	Шинжээчдийн дүгнэлт	Дүүргийн байгаль орчны газар	“Алтан тариа” ХХК	
Бүх шатны Засаг дарга, Байгаль орчны улсын байцаагч, орон нутгийн байцаагч	Хуралд танилцуулах, Уулзалт	БОМТ-ийн тухайн жилийн тайлан, Ирэх оны төлөвлөгөө	12-р сарын 1-ний дотор	БОХ арга хэмжээний тайлан, ирэх оны төлөвлөгөөг танилцуулах, санал авах, хамтран ажиллах	Дүүрэг, хороо	“Алтан тариа” ХХК	
Төрийн бус байгууллагууд, олон нийт			Жил бүр 1 удаа		Тухайн үед сонгох	“Алтан тариа” ХХК	
Төрийн захиргааны төв байгууллага	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр		12-р сарын 10-ний дотор	Хянуулах батлуулах	Улаанбаатар хот	“Алтан тариа” ХХК	

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах арга хэмжээ						
БОМТ хэрэгжилтийг тайлагнах, оролцох талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
БОУАӨЯ, ХБОВХГ	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр	БОМТ-ийн тухайн жилийн тайлан	Жил бүр 1 удаа	-	-	“Алтан тариа” ХХК
БОУАӨЯ, ХБОВХГ	Тайлан, төлөвлөгөөг цаасан хэлбэрээр	БОМТ-ийн тухайн жилийн тайлан	Тухайн жилийн 11-12 сарын дотор	-	-	

Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний 2025 оны зардлыг дараах хүснэгтэд харуулав.

Зардлын хэлбэр	Нийт зардал, төг
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	2.200.000
Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1.909.000
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал	650.000
Осол, эрсдлийн төлөвлөгөөний зардал	220.00
Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө	1.580.000
Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	12.300.000
БОМТ-г хэлэлцүүлэх, тайлагнах зардал	-
Орчны хяналт шинжилгээний зардал	2.540.000
Нийт	21.399.000

“Алтан тариа” ХХК-ийн “Турил, тэжээлийн үйлдвэр” төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **21.399.000** (хорин нэгэн сая гурван зуун ерэн есөн сая) төгрөг болж байна.

15. ДҮГНЭЛТ

“Алтан тариа” ХХК-ийн “Гурил, тэжээлийн үйлдвэр” төсөл нь Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хэрэгжинэ. Төслийг хэрэгжүүлэн үйл ажиллагаагаа явуулж буй “Алтан тариа” ХХК нь тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ. 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **21.399.000** төгрөг зарцуулагдах урьдчилсан дүн гарсан байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн бичиг баримт юм.

Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 11 дүгээр сарын 01-ний дотор төсөл хэрэгжүүлж байгаа БОУАӨЯ, аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлэх шаардлагатай.